



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 1/512

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.6, 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит XXVIII хуралдааны XXVIII/37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд, өсвөр үеийнхний урлагийн боловсрол, гоо зүйн мэдрэмжийг нэмэгдүүлэх, авьяас чадварыг нээн илрүүлж, хөгжүүлэх, нутгийн ардын онцлог бүхий өв соёлыг өсвөр хойч үедээ өвлүүлэн сурталчлах, эх оронч үзэл төлөвшүүлэх зорилгоор зохион байгуулах “Аймгийн хүүхдийн урлагийн наадам”-д оролцсон авьяаслаг хүүхдүүдийг шагнаж урамшуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 7,000,000 (долоон сая) төгрөгийг “Гэр бүлийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал”-аас гаргаж зарцуулахыг ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны...10-р сарын 30-ны
өдрийн 1/512 захирамжийн хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮҮХДИЙН УРЛАГИЙН НААДАМД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ

№	Материалын нэр	Зориулалт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өргөмжлөл	А-3 хэмжээтэй хамтлаг төрөлд эхний 5 байранд орсон хүүхдүүдэд	ш	40	8,000	320,000
2	Өргөмжлөл	А-4 хэмжээтэй гоцлол төрөл шалгарсан хүүхдүүдэд	ш	40	2,500	100,000
3	Медаль	6 байранд шалгарсан хүүхдэд	ш	24	9,000	216,000
4	Алт мөнгө хүрэл пайз	10 байранд шалгарсан хамтлагын шагнал	ш	40	20,000	800,000
5	Жааз	10 байранд шалгарсан хамтлаг төрлийн хүүхдүүдэд	ш	40	28,000	1,120,000
6	Жааз	10 байранд шалгарсан гоцлол	ш	40	15,000	600,000
7	Цом	Шилдэг сургуулиар шалгарсан сургуульд	ш	4	80,000	320,000
8	Өргөмжлөл	Шилдэг 4 сургуульд АЗ	ш	4	55,000	220,000
9	Номинацийн шагнал	2 сурагчид өгөх шагнал-медаль өргөмжлөл	ш	2	25,000	50,000
10	Номинацийн шагнал	2 сурагчид өгөх шагнал-медаль өргөмжлөл	ш	2	25,000	50,000
11	Номинацийн шагнал	2 сурагчид өгөх шагнал-медаль өргөмжлөл	ш	2	25,000	50,000
12	Талархалын бичиг	Оролцсон сургуулиудад жаазтай	ш	28	15,000	420,000
13	Өдрийн хоол	3 Шүүгч болон зохион байгуулагчдад 4 удаагийн хоол	ш	32	21,062,5	674,000
14	Ус	Шүүгч нар, зохион байгуулагчдад	ш	40	1,500	60,000
15	Дэлгэц	Арын фон,лед дэлгэц	өдөр	2	1,000,000	2,000,000
Нийт						7,000,000